



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРТ ИРГЭНИЙ ГОМДЛЫН ДАГУУ
ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН
ХШҮДАГ/2025/ХШ-01**

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРТ ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 05/5480 дугаар албан бичигт дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор шалгалтыг гүйцэтгэлээ.

Ажлын хэсэгт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Г.Шүрэндолгор, гэрээт ажилтан О.Пүрэвсүх нар ажиллалаа.

Батлагдсан удирдамжийн “Тав.Хяналт шалгалтын хамрах хүрээ, чиглэл” хэсэгт заасны дагуу Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 05/5480 дугаар албан бичигт дурдсан дараах асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. “Цөмөөхөй” балетын тоглолтын орлогын тайзны түрээсийн орлогын бүрдүүлэлтийг шалгах;
2. “Цөмөөхөй” балетын тоглолтын үеэр цай, кофе, уух зүйлс болон модон хүүхэлдэйн худалдаа хийхэд түрээсийн төлбөр төлөгдсөн эсэхийг шалгах;
3. Театрын дулааны шугамын урсгал засварыг тендер сонгон шалгаруулалт явуулахаас зориудаар зайлсхийж, бага дүнгээр олон этгээдээр хуваан гүйцэтгүүлсэн эсэхийг шалгах;
4. Театрын ариун цэврийн өрөөний засварыг тендер сонгон шалгаруулалтгүй гүйцэтгүүлж байгаа эсэхийг шалгах;
5. Тайз түрээслүүлэх журмыг зөрчиж зарим байгууллага, хувь хүнд үнэгүй ашиглуулдаг эсэхийг шалгах;
6. Захирлын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/430, 2024 оны 12 дугаар сарын Б/434 дүгээр тушаалын дагуу нэр бүхий ажилтан, албан хаагчдад тэтгэмж олгосон зардлыг шалгах;

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. “Цөмөөхөй” балетын эрх, нэмэлт орлого, хандив, тусламжийн хөрөнгийн бүртгэл, ашиглалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт

1.1 Гомдолд “Цөмөөхөй” балет 10 удаа тоглогдсон ч театрт ямар хэмжээний орлого орсон нь тодорхойгүй” гэснийг шалгалаа.

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/106 дугаар тушаалаар барааны тэмдэг эзэмших онцгой эрхийг “Монголын

балетын хөгжил сан” ТББ-д олгож, “Цөмөөхөй” бүжгэн жүжгийн барааны тэмдгийг 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр улсын бүртгэлийн 40-0027804 дугаарт бүртгэсэн байна.

“Монголын балетын хөгжил сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Энхсүвдын 2024 оны 11-р сарын 28-ны өдрийн 11/15 дугаар албан бичгээр “Цөмөөхөй” бүжгэн жүжгийн барааны тэмдгийн эрх, партитур, цомнол, тайзны иж бүрдэл, хувцасны иж бүрдэл, тайз, хувцасны эскиз зэргийг Дуурь бүжгийн эрдмийн театрт үнэ төлбөргүй **бэлэглэлийн үндсэн дээр шилжүүлэхээр** болсноо мэдэгдсэн тул 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн ДБЭТ-ын Уран сайхны Зөвлөлийн хурлаар хэлэлцэж тус театрын захирлын А/46 дугаар тушаалаар Ажлын хэсэг томилогдон хөрөнгийг хүлээн авсан байна. Ингэснээр тус театр нь “Цөмөөхөй” бүжгэн жүжгийг тоглох, түүнээс олсон орлогыг захиран зарцуулах боломжтой болжээ.

ДБЭТ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуягийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/10 дугаартай “Урын санд уран бүтээл хүлээж авах тухай” тушаалаар “Цөмөөхөй” бүжгэн жүжгийн оюуны өмчийн эрх, партитур, цомнол, тайзны иж бүрдэл, хувцасны иж бүрдэл, тайз, хувцасны эскиз зэрэг иж бүрдлээр нь театрын **урын санд бүртгэх шийдвэр гарчээ.**

“Цөмөөхөй” жүжгийг 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүртэл нийт 9-н удаа тайзнаа тоглож тасалбарыг тикет.мн-ээр болон театрын кассаар борлуулсан байна. Тикет.мн-ээр дамжуулан 2570 ширхэг тасалбар зарж 179,400.0 мянган төгрөгийн борлуулалт хийснээс борлуулалтын шимтгэлд 8,970.0 мянган төгрөг суутгуулж, театрт 170,430.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Театрын кассаар 1163 ширхэг тасалбар зарж 83,560.0 мянган төгрөгийн орлого олсон нь анхан шатны баримтаар нотлогдож байна. “Цөмөөхөй” бүжгэн жүжгээс нийт 253,990.0 мянган төгрөгийн орлого олж, нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжийн дагуу бүртгэж, **санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан** байна.

“Цөмөөхөй” бүжгэн жүжгийн орлогыг Захирлын 2024 оны А/51, А/52 дугаар тушаалаар ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах гэсэн 2 чиглэлээр 229,560.8 мянган төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “*Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам*” -ын 5.1.3 нийт ажилчдын **нийгмийн асуудлыг шийдвэрлэх**, 5.5.1 тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, **урсгал засварын ажил**” -д зарцуулах заалтуудтай нийцсэн гэж дүгнэв.

1.2 Гомдолд “Тоглолтод оролцох бүх хүүхдүүдээс хандив авсан, уг тоглолтын үеэр театр дээр цай, кофе, уух зүйлс болон модон хүүхэлдэйн худалдааг түрээсгүй ажиллуулсан” гэснийг шалгалаа.

“Цөмөөхөй” бүжгэн жүжиг нь 2024 оны 12 дугаар сард 9 удаагийн тоглолтын 6 өдөр үзэгчдэд цай, кофегоор үйлчлэх зориулалтаар 2 түрээсийн гэрээ байгуулсан байна.

- Театрын өлгүүрийн буланд байрлах 12м.кв талбайг иргэн Б.Биндэрьяа -д түрээслүүлэх гэрээ байгуулж, талбайн м.кв-ыг өдрийн 10.0 мянган төгрөгөөр тооцон, түрээсийн төлбөрийг нэг бүрийн үнэ нь 3600 төгрөгийн үнэтэй 200ш жигнэмэг буюу 720.0 мянган төгрөгийн бартераар барагдуулсан байна.
- Театрын үүдний хэсэгт байрлах 3м.кв талбайг Монголын балетын хөгжил сан ТББ -д түрээслүүлэх гэрээ байгуулж, талбайн м.кв-ыг өдрийн 15.0 мянган төгрөгөөр тооцон 270.0 мянган төгрөгийн бартераар байгууллагын ажилчдын хүүхдүүд болон тоглолтод оролцсон хүүхдүүдэд гардуулах бэлэг өгөхөөр тохиролцсон байна.

Гэрээний гүйцэтгэлийг хянахад гэрээг дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийг хэрхэн хангасан тухай тайлан байхгүй, бартерын орлогыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг ерөнхий нягтлан бодогч, нярав мөн чиг үүргийн хүрээнд гэрээ хэлэлцээрт хяналт тавих, гэрээний биелэлтийг дүгнэх эрх бүхий албан тушаалтан нар нь Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/17 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- “Ерөнхий нягтлан бодогч буюу санхүүгийн албаны дарга”-ын албан тушаалын тодорхойлолтын 3 дугаар зорилтод заасан “Байгууллагын санхүүгийн бүртгэл тооцоо, тайлан тэнцлийг хуулийн хугацаанд НББ хууль, УСНББОУС, СТОУС, бусад санхүү, татварын бүх төрлийн хууль тогтоомжийн хүрээнд **нэгтгэх тайлагнах**, дүн шинжилгээ хийж удирдлагад мэдээлэх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хяналт тавих” ;
- “Нярав”-ын албан тушаалын тодорхойлолтын 1 дүгээр зорилтод заасан “Нягтлан бодох бүртгэлийн **анхан шатны бүртгэл хөтлөх, тайлан гаргах**”;
- “Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга”-ын албан тушаалын тодорхойлолтын 4 дүгээр зорилтод заасан “Театрын тайз түрээсийн гэрээ байгуулан хяналт тавьж ажиллах, аливаа хийгдэж буй **гэрээ хэлэлцээрт хяналт тавин үнэлэлт дүгнэлт, зөвлөгөө өгөн шийдвэрлэн ажиллаж гэрээний биелэлтийг дүгнэх**” гэсэн чиг үүргээ тус тус хангалтгүй биелүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Хоёр. Байгууллагын нэмэлт үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, ашиглалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт

2.1. Гомдолд “Театрын тайз түрээслүүлэх журмыг зөрчиж зарим байгууллага, хувь хүнд үнэгүй ашиглуулдаг гэснийг шалгахад:

Тус байгууллагад тайзны түрээсийн төлбөрийг зохицуулсан журам батлагдаагүй, хөдөлмөрийн дотоод журмын 6.18-д тайзны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх тухай заалт байна. Тайлант онд Захирлын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Тайз түрээсийн үнэ, жилийн суудлын үнийн тарифийг шинэчлэн батлах тухай” А/27 дугаар тушаалыг мөрдөж тайз түрээсийн гэрээг байгуулж иржээ. Тус тарифаар тайзны түрээсийг 5 цаг ба түүнээс дээш хугацаатай ашиглавал 12,000.0

мянган төгрөгөөр тооцохоор баталсан боловч Авлигатай тэмцэх газрын 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 03/17361 дугаар албан бичгээр ирүүлсэн “Зөвлөмж”-ийн дагуу тус тушаалыг Захирлын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалаар хүчингүй болгожээ.

Тус тушаал хүчингүй болсонтой холбогдуулан Тайз түрээсийн үйлчилгээний үнэ, жилийн суудлын үнийн тарифыг шинэчлэх саналаа дээд шатны байгууллагад хүргүүлэх үүргийг Маркетинг төлөвлөлтийн албаны түр орлон гүйцэтгэгч Б.Бямба-Ёндонд өгсөн байна. Дээрх саналыг ССАЖЗЯ -нд хүргүүлсэн эсэхийг тодруулахад энэ үүргийг хариуцсан Маркетинг төлөвлөлтийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бямба-Ёндон өөрийн хүсэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр ажлаас чөлөөлөгдсөн ба эцэслэн шийдээгүй байна.

Тайз түрээсийн 2024 онд нийт 21 гэрээг хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан ба үүнээс 3 байгууллагатай тайзыг үнэгүй ашиглуулахаар буюу түрээсийн төлбөрийг 100% хөнгөлөхөөр гэрээлсэн байна. Тэдгээр байгууллагыг дурьдвал:

1. Соёл урлагийн их сургуулийн хөгжмийн урлагийн сургуулийн Сонгодог урлагийн тэнхимээс зохион байгуулсан Монгол Улсад мэргэжлийн дуулаачийн сургалт үүссэний 60 жилийн ойд зориулсан “Зуун дамнасан дуун жаран” тоглолт;
2. Зууны манлай Пүрэвдорж сангаас зохион байгуулсан Монгол улсын хөдөлмөрийн баатар, ардын жүжигчин, ХХ зууны манлай дуурийн дуучин, профессор Ц.Пүрэвдоржийн нэрэмжит Ари романс дуулаачдын Олон Улсын VI уралдааны III шатны шалгаруулалт, шагнал гардуулах арга хэмжээ;
3. Монгол Японы соёлын харилцааг дэмжих Альянс нийгэмлэгээс зохион байгуулсан Монгол Японы 50 жилийн хүндэтгэлийн тоглолт арга хэмжээ.

Дээрх гэрээнд заасан тоглолт арга хэмжээний 2 тоглолт, арга хэмжээг ССАЖЗЯ-аас албан бичгээр ирүүлсэн “Дэмжин ажиллах хүсэлт”-ийн дагуу, нөгөө 1 гэрээнд заасан тоглолтыг салбарын буюу тус байгууллагын хүний нөөц болох дараа дараагийн залгамж холбоог бэлтгэдэг чухал хамтран ажиллагч байгууллагын хувьд дэмжин ажилладаг гэх үндэслэлээр төлбөрөөс чөлөөлсөн байна.

Эдгээр гэрээнүүд нь холбогдох хууль, журмыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2.2. Гомдолд “Театрын дулааны шугамын засварыг тендер сонгон шалгаруулалт явуулахаас зориудаар зайлсхийж, бага дүнгээр олон этгээдээр хуваан гүйцэтгүүлж нийт 48.9 сая төгрөгийг төсвөөс олгосон боловч бодит өртөг нь 15-25 сая төгрөгт багтах ажил хийгдсэн, мөн засварын ажил гэх байдлаар 2024 оны 12 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд 6 иргэн, ААН-д нийт 67.6 сая төгрөг шилжүүлсэн нь мөн дээрхийн адил нэг ажлыг олон хэсэглэж олгон тендер шалгаруулалтаас зайлсхийсэн бодит зориулалт үр дүн нь тодорхойгүй, театрын ариун цэврийн өрөөний засварыг тендер сонгон шалгаруулалтгүй гүйцэтгүүлж байгаа” гэснийг шалгалаа.

Байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлогоос Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” -ын 5.5.1-д “Тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, **урсгал засварын ажил**” -д зарцуулах гэсэн заалтыг үндэслэн, хамт олны гаргасан саналын

дагуу Захирлын 2024 оны А/12, А/30, А/52 дугаар тушаалаар 155.7 сая төгрөгийг урсгал засварын бараа материал худалдан авах, урсгал засвар хийх зардалд төсөвлөн зарцуулжээ.

Урсгал засварын бараа материал нийлүүлсэн, засвар гүйцэтгэсэн иргэн, аж ахуй нэгжийн товч мэдээлэл

№	Тушаалын дугаар, төсөв	Иргэн, ААН-ийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн	Гүйцэтгэсэн ажлын нэр
1	2024 оны А/12 тушаалаар 15.0 сая төгрөг	Бүдүн сан ХХК	2024.08.12	9,277.5	Фитнесийн өрөөний засвар
2	2024 оны А/30 тушаалаар 25.0 сая төгрөг	Браунс луд ХХК	2024.07.01	19,900.0	Найруулагчийн өрөөний засвар
3		Гүн амжилт зориг ХХК	2024.07.01	19,500.0	Балетын 306,307,308 өрөөний засвар
4	2024 оны А/52 тушаалаар 119.7 сая төгрөг	Л.Батсайхан /ХМ70103077/	2024.11.30	18,926.9	Дулааны шугам сүлжээ /халаалтын төхөөрөмж нийлүүлэх/
5		БНББ трейд ХХК	2024.12.03	19,688.0	Дулааны шугам сүлжээ засвар /материал нийлүүлэх/
6		Ган жигүүр констракшн	2024.12.02	18,000.0	Дулааны шугам сүлжээ засвар
7		Хас билгүүн тулга констракшн	2024.12.03	19,946.6	Ариун цэврийн өрөөний засвар
8		Ц.Оюун /ЧВ67091808/	2024.12.17	17,600.0	Ариун цэврийн өрөөний цэвэр, бохир усны шугам засвар
9		Ц.Баярсайхан /УК95020311	2024.12.17	15,837.6	Ариун цэврийн өрөөний материал нийлүүлэх
Нийт дүн				158,676.6	

Дулааны шугам сүлжээ, өрөөний засвар, ариун цэврийн өрөөний засварын ажлыг гүйцэтгэхээр 6 аж ахуй нэгж, 3 иргэнтэй 158,676.5 мянган төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаанд 45,620.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр үлдэгдэл санхүүжилт 113,056.4 мянган төгрөгийг бүрэн олгосон байна. Урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн иргэн, аж ахуй нэгжийн ажлын гүйцэтгэлийн явц, үр дүнг санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн нягтлан шалгав. Үүнд:

Захирлын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн **А/12 дугаар тушаалаар** урсгал засварт 15,000.0 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр “Бүдүнсан” ХХК-нд 4,400.0 мянган төгрөг, “Гүн амжилт зориг” ХХК -нд 5,000.0 мянган төгрөг, “Браунс луд” ХХК-д 4,900.0 мянган төгрөг, нийт 14,300.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ хийсэн байна.

- “Бүдүнсан” ХХК-тай 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр фитнесийн өрөөний 98м2 талбайд бүрэн засвар хийхээр 9,277.5 мянган төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрийг захирлын 2024 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн 4,400.0 мянган төгрөгийг 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр төлсөн. Уг засварын ажлын зураг төсөв байхгүй, гүйцэтгэгч компанийн хийсэн

ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, захиалагч талаас гэрээний 4.1 дэх заалтын дагуу ажлыг хүлээн авч дүгнэсэн акт, хурлын тэмдэглэл байхгүй байхад үлдэгдэл төлбөр 4,877.5 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр төлсөн.

Захирлын 2024 оны 06 дугаар сарын 24-ний **A/30 тушаалаар** урсгал засварт 25,000.0 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр “Браунс луд” ХХК нд 15,000.0 мянган төгрөг, “Гүн амжилт зориг” ХХК -нд 10,000.0 мянган төгрөг, нийт 25,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ хийсэн байна.

- Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 7-н хүний бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж ерөнхий найруулагчийн 300м2 талбайтай өрөөг “Браунс луд” ХХК-аар, балетын өрөөний 306, 307, 308 өрөөнүүдийг “Гүн амжилт зориг” ХХК-иар тус тус засварын ажлыг хийлгэхээр шийдвэр гаргаж тухайн өдөр “Браунс луд” ХХК -тай 19,900.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 15,000.0 мянган төгрөгийг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр захирлын 2024 оны A/30 тушаалыг үндэслэн шилжүүлсэн. Эдгээр засваруудад засварын ажлын зураг, төсөв хийгдээгүй, гүйцэтгэгч компаниас үнийн санал өгөөгүй, ажлын явцын зураг, гүйцэтгэлийн тайлан байхгүй, гэрээний 4.1 дэх заалтын дагуу гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байхад үлдэгдэл төлбөр 4,900.0 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр гүйцэтгэгчид төлсөн.
- 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр “Гүн амжилт зориг” ХХК-тай 19,688.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа төлбөрт 10,000.0 мянган төгрөгийг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр захирлын 2024 оны A/30 тушаалыг үндэслэн, 08 дугаар сарын 13-ны өдөр 5,000.0 мянган төгрөгийг захирлын 2024 оны A/12 дугаар тушаалыг үндэслэн тус тус шилжүүлсэн байна. Уг ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, гэрээний 4.1 дэх заалтын дагуу гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байхад үлдэгдэл төлбөр 4,500.0 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр төлсөн.

Захирлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн **A/52 дугаар тушаалаар** урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 119,650.8 мянган төгрөг зарцуулахаар баталсан. Гүйцэтгэлээр иргэн Л.Батсайханд 18,926.9 мянган төгрөг, “БНББ” ХХК-нд 19,688.0 мянган төгрөг, “Ган жигүүр констракшн” ХХК-нд 18,000.0 мянган төгрөг, “Хас билгүүн тулга констракшн” ХХК-нд 19,946.5 мянган төгрөг, “Гүн амжилт зориг” ХХК -нд 4,500.0 мянган төгрөг, “Бүдүнсн” ХХК-нд 4,877.5 мянган төгрөг, Ц.Оюун 17,600.0 мянган төгрөг, Б.Цолмон 15,837.5 мянган төгрөг, нийт 119,376.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ хийсэн байна.

- Иргэн Л.Батсайхан /ХМ70103077/-тай 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр халаалтын тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээ байгуулан, урьдчилгаа 11,220.2 мянган төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр шилжүүлсэн. Гэрээний 4.2-ын дагуу хөрөнгө, бараа материал хүлээн авах актыг 12 дугаар сарын 16-ны өдөр үйлдсэн боловч нярав О.Энхцэцэг гарын үсэг зураагүй, бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байна. Бараа материалын үлдэгдэл төлбөр 7,706.7 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар

сарын 26-ны өдөр захирлын 2024 оны А/52 дугаар тушаалыг үндэслэн шилжүүлсэн.

- “БНББ” ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр захирлын А/52 дугаар тушаалыг үндэслэн 19,688.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр төлбөрийг бүрэн шилжүүлэн, гэрээний 7.1-д заасны дагуу засварын материал худалдан авсан гэрээ дүгнэсэн акт үйлдсэн боловч нярав О.Энхцэцэг гарын үсэг зураагүй, бараа материалын данс бүртгэлд тусгаагүй байна.
- “Ган жигүүр констракшн” ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр халаалтын узелийн засварын ажил гүйцэтгэх гэрээг 18,000.0 мянган төгрөгөөр байгуулжээ. Гэрээний 2.2-т урьдчилгаа төлбөрийг 80 хувиар хийхээр заасан боловч захирлын 2024 оны А/52 дугаар тушаал, гэрээ, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна. Гэрээний 7.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж, засвар хийх явцын зураг хавсаргасан байна.
- “Хас билгүүн тулга констракшн” ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Захирлын 2024 оны А/52 дугаар тушаалыг үндэслэн ариун цэврийн өрөөний засвар хийлгэхээр 19,946.5 мянган төгрөгийн үнийн санал авч гэрээг байгуулжээ. Гэрээний 3.3-т урьдчилгаа төлбөрийг 50 хувиар хийхээр заасан боловч урьдчилгаа олгоогүй, гэрээнд хийгдэх ажил, талбайн хэмжээг тодорхой зааж, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр төлсөн.
- Иргэн Ц.Оюун /ЧВ67091808/ нь 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ариун цэвэр, бохир усны дотоод шугам сүлжээ шинээр угсарч суурилуулах, хуучин шугам сүлжээ буулгах ажлын хөлс, үнийн саналыг 17,600.0 мянган төгрөг байхаар ирүүлсэн. Захиалагч тал энэ үнийн саналыг үндэслэж 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр гэрээ байгуулж, ажил гүйцэтгэсний дараа гэрээний 4.1-дэх заалтын дагуу 12 дугаар сарын 26-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 17,600.0 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн.
- Иргэн Б.Цолмон /УК95020311/ нь 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр ариун цэврийн өрөөний засварын бараа материал нийлүүлэх 15,837.5 мянган төгрөгийн үнийн саналыг ирүүлсэн байна. Захиалагч тал энэ үнийн саналыг зөвшөөрч 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр түүнтэй гэрээ байгуулсан байна. Бараа материалыг хүлээн авсны дараа гэрээний 4.1-дэх заалтын дагуу гэрээ дүгнэсэн актыг 12 дугаар сарын 26-ны өдөр үйлдсэн боловч гэрээгээр хийсэн ажлын үр дүнг хүлээлгэж өгсөн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдөр гэж тайлагнасан байна. Бараа материалын төлбөр 15,837.5 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр төлсөн. Нярав О.Энхцэцэг эдгээр бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Дулааны шугам сүлжээ, өрөөний засвар, ариун цэврийн өрөөний засварын ажлыг гүйцэтгэхээр 6 аж ахуй нэгж, 3 иргэнтэй 158,676.5 мянган төгрөгийн гэрээ байгуулсан нь худалдан авах ажиллагааны тухай хуулийн босго үнээс давсан тул нээлттэй тендер зарлах эрх зүйн зохицуулалттай гэтэл хэд хэдэн аж ахуй нэгж,

иргэнд хувааж шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.3 дэх хэсэгт заасан “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” зарчмын 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан заалт, 24 дүгээр зүйлийн 24.4-т заалттай тус тус нийцэхгүй байна.

Гэрээт ажлыг гүйцэтгэсэн Ган жигүүр констракшн ХХК, БНББ трейд ХХК, Хас билгүүн тулга констракшн ХХК, иргэн Ц.Оюун, Б.Цолмон, Л.Батсайхан нараас ажил хүлээн авсан акт үйлдсэн байна. Бусад 3 гүйцэтгэгчийн гэрээт ажлыг хүлээн авсан тухай акт байхгүй байна.

Бараа материал бэлтгэн нийлүүлсэн 2 иргэн, 1 аж ахуй нэгжээс худалдан авсан 54,452.5 мянган төгрөгийн эд материалыг 2024 оны санхүүгийн тайланд бараа материалын орлогоор бүртгээгүй, шууд зардалд бүртгэж зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-т “байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузэл сууриар хөтөлнө”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Мөн Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын орлогын баримт, зарлагын баримт бүрдүүлэх заавар, үндсэн хөрөнгийн өргөтөл, сайжруулалт, их засварыг хүлээн авахад бүрдүүлэх зааврыг мөрдөөгүй байна.

Эдгээр хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүргийн албан тушаалтан нь Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/17 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн байна. Тухайлбал:

- “Ерөнхий нягтлан бодогч буюу санхүүгийн албаны дарга”-ын албан тушаалын тодорхойлолтын **3 дугаар зорилтод заасан** “Байгууллагын санхүүгийн бүртгэл тооцоо, тайлан тэнцлийг хуулийн хугацаанд НББ хууль, УСНББОУС, СТОУС, бусад санхүү, татварын бүх төрлийн хууль тогтоомжийн хүрээнд **нэгтгэх тайлагнах**, дүн шинжилгээ хийж удирдлагад мэдээлэх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хяналт тавих”
- “Нярав”-ын албан тушаалын тодорхойлолтын 1 дүгээр зорилтод заасан “Нягтлан бодох бүртгэлийн **анхан шатны бүртгэл хөтлөх, тайлан гаргах**”
- “Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга”-ын албан тушаалын тодорхойлолтын 4 дүгээр зорилтод заасан “Театрын тайз түрээсийн гэрээ байгуулан хяналт тавьж ажиллах, аливаа хийгдэж буй **гэрээ хэлэлцээрт хяналт тавин, үнэлэлт дүгнэлт, зөвлөгөө өгөн шийдвэрлэн ажиллаж, гэрээний биелэлтийг дүгнэх**” 5 дүгээр зорилтод заасан “**Театрын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус урсгал засварын ажлыг хариуцан гүйцэтгүүлэх**, шаардлагатай асуудлыг

захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх” гэсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

2.4 Гомдолд дурдагдсан “Захирлын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/430, 2024 оны 12 дугаар сарын Б/434 дүгээр тушаалын дагуу нэр бүхий ажилтан, албан хаагчдад тэтгэмж олгосон” зардлын зориулалтыг хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шалгахад:

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 1,484.0 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд уг дүнг Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан байна.

**Үндсэн үйл ажиллагааны 2024 оны орлогын бүрдүүлэлт,
зарцуулалтын тайлан**

/мянган төгрөгөөр/

№	ДАНСНЫ АНГИЛАЛ	ЗАРЦУУЛАЛТ ЭРХ НЭЭЛГЭСЭН ДҮН	ЗАРЦУУЛАЛТ	ХУВЬ
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,484,032.5	1,484,032.5	100.0
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,484,032.5	1,484,032.5	100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,484,032.5	1,484,032.5	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА	1,457,738.6	1,479,382.5	101.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,164.6	891,231.8	96.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	68,950.0	68,950.0	100.0
210102	Нэмэгдэл	68,950.0	68,950.0	100.0
2102	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	8,618.8	8,618.8	100.0
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	8,618.8	8,618.8	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	43,461.0	40,910.9	94.1
210401	Бичиг хэрэг	5,500.0	4,605.1	83.7
210402	Тээвэр, шатахуун	-	600.0	
210403	Шуудан, холбоо, интернэт	2,450.0	1,800.0	73.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон шавж устгах	5,816.0	3,024.0	52.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх зардал	29,695.0	30,881.8	104.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	298,321.5	285,646.6	95.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000.0	14,850.7	99.0
210602	Тавилга	34,894.0	33,957.8	97.3
210604	Урсгал засвар	248,427.5	236,838.1	95.3
2107	Томилолт, зочны зардал	14,790.0	14,790.0	100.0
210702	Дотоод албан томилолт	14,790.0	14,790.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	471,917.5	456,209.7	96.7
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	468,917.5	453,209.7	96.7
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох зардал	3,000.0	3,000.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,105.9	16,105.9	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,105.9	16,105.9	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	535,574.0	588,150.7	109.8

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	535,574.0	533,699.7	99.7
300011	Орлого төвлөрүүлэлт	-	54,451.0	
	Зарцуулалтын эрх нээлгээгүй дүн	21,643.9	-	
	Мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл	4,650.0	4,650.0	

Тайлант хугацаанд цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 68,950.0 мянган төгрөг, ажил ологчоос төлөх шимтгэлийн зардалд 8,618.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 535,574.0 мянган төгрөг нийт 613,322.8 мянган төгрөгийн эрх нээлгүүлэн, захирлын баталсан 7 удаагийн тушаал, 1 гэрээний дагуу цалин урамшуулал, шимтгэлийн зардалд 77,568.8 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 533,699.7 мянган төгрөгийг зарцуулж 2,054.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Цалин урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардал баталсан захирлын тушаал, гэрээ, гүйцэтгэлийн мэдээ

Д/д	Гэрээ, тушаалын огноо, дугаар	Гэрээ, тушаалын утга	Хавсралтад баталсан		Гүйцэтгэл	
			Ажилтны тоо	Мөнгөн дүн мян.төг	Ажилтны тоо	Мөнгөн дүн мян.төг
1	2024 оны 07-р сарын 18-ны өдрийн Б/247	Урамшуулалт цалин олгох тухай	4	10,012.5	4	10,012.5
2	2024 оны 07-р сарын 30-ны өдрийн Б/250	Мөнгөн урамшуулал олгох тухай	93	67,556.3	87	67,556.3
	Цалин, хөлсний зардал		97	77,568.8	93	77,568.8
3	2024 оны 07-р сарын 08-ны өдрийн Б/246	Тэтгэмж олгох тухай	11	113,930.0	11	113,930.0
4	2024 оны 12-р сарын 05-ны өдрийн Б/414	Тэтгэмж олгох тухай	175	17,500.0	165	16,500.0
5	Хамтран ажиллах гэрээ 2024 оны 09-р сарын 02-ны өдрийн №01	Эрүүл мэндийн үзлэг	245	10,780.0	245	9,725.7
6	2024 оны 12-р сарын 23-ны өдрийн Б/430	Тэтгэмж олгох тухай	7	70,000.0	7	70,000.0
7	2024 оны 12-р сарын 23-ны өдрийн Б/430	Тэтгэмж олгох тухай	8	240,000.0	8	240,000.0
8	2024 оны 12-р сарын 26-ны өдрийн Б/434	Тэтгэмж олгох тухай	10	83,544.0	10	83,544.0
	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал		456	535,754.0	446	533,699.7
	НИЙТ ДҮН		553	613,322.8	539	611,268.5

Дэлхийн сонгодог урлагийн өндөр зэрэглэлийн домогт дуучдын хамтарсан тоглолтод ажиллах 93 ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн урамшуулал олгох, Монгол улсын банкны салбарын 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд ажилласан 4

албан хаагчдад цалин урамшуулал олгох тушаалын дагуу нийт 77,568.8 мянган төгрөгийг цалингийн нэмэгдэл урамшууллын зардалд зарцуулсан байна.

Байгууллагын ахмад ажилтан 165 хүнд 16,500.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, Халдвар судлалын үндэсний төвтэй байгуулсан гэрээний дагуу 245 ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн зардалд 9,725.7 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна.

Захирлын 4 удаагийн тушаалаар 36 ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 507,474.0 мянган төгрөгийг олгож, үүнээс 8 ажилтанд орон сууцны урьдчилгаа төлбөрт 240.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 5.1.2 “байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах”, 5.1.3 “нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх”* гэсэн заалтын зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ үндсэн үйл ажиллагааны орлогын **нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй** байна гэж тогтоосон байна.

Дээрх шаардлагыг хангасан эсэхийг нягтлахад үндсэн үйл ажиллагааны орлогын дүнгийн 41.2 хувь буюу 611,268.5 мянган төгрөгийг эдгээр 2 зардлын ангиллаар зарцуулсан тул хууль тогтоомжид нийцүүлэн ажилласан гэж дүгнэв.

Дуур бүжгийн эрдмийн театрын захирлын 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/08 тоот тушаалын 01 дүгээр хавсралтаар баталсан *“Хөдөлмөрийн дотоод журам”-ын:*

- 12.1.11. *Захиргаа нь тухайн жилийн төсвийн болон бусад орлогын байдал, цалингийн фондын хэмнэлт, эдийн засгийн бусад байдлаас хамаарч нэмэлт бусад урамшуулал өгч болно.*
- 12.1.15. *Уран бүтээлч, ажилтнуудын нийгмийн баталгааг ханган, дэмжлэг үзүүлэх зорилгоор гэр хороололд амьдарч буй өрх толгойлсон эмэгтэй /эрэгтэй/ -д түлээ нүүрсний хөнгөлөлтийг жилд 1 удаа буюу 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж болно.*
- 12.3. *Байгалийн гамшиг, үер, ус гал түймрийн аюулд орон гэр нь өртсөн ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ...* гэсэн буцалтгүй тусламж, урамшуулал олгох талаар 3 заалт байна.

Харин орон сууцны урьдчилгаа төлбөрийн тэтгэмж олгох талаар зохицуулалт байхгүй байна.

Орон сууцны урьдчилгаа төлбөрийн тэтгэмж олгох асуудлыг хэлэлцсэн Захиргааны зөвлөлийн болон хамт олны хурлын тэмдэглэлд орон сууцны урьдчилгаа төлбөрийн тэтгэмж авах ажилтанд тавих шалгуур үзүүлэлтийг *тус театрт 5-аас дээш жил ажилласан, орон сууцгүй, ажлын гүйцэтгэл, үр дүн сайтай, залуу гэр бүлд олгохоор дурдсан боловч энэ шалгуурыг албан ёсоор баталгаажуулсан шийдвэр байхгүй* байна. Орон сууцны урьдчилгаа төлбөрийн тэтгэмж авсан 8 ажилтнаас захиргаанд хандсан өргөдөл хүсэлт гаргаагүй, ажилтны орон байрны судалгаа, алба, нэгжийн хамт олны хурлын шийдвэр, саналыг үндэслэн Захиргааны зөвлөлөөс эцсийн шийдвэрийг гаргаж уг тэтгэмжийг олгосон байна.

ДБЭТ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянан үзэхэд 12 дугаар сард нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгосон 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий 23 удаагийн 390.0 сая төгрөгийн гүйлгээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн боловч тухай бүр буюу уг гүйлгээг хийснээс хойш 7 хоногийн дотор мэдээлэх ёстой хугацааг 14 удаа хэтрүүлсэн алдаа гаргасан, мөн 2024 онд гаргасан тэтгэмж урамшуулал, цалин олгох тухай Захирлын 8 удаагийн 613.3 сая төгрөгийн тушаалыг Шилэн дансанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5, 6.4.8-дахь заалтын хэрэгжилтийг хангаагүй байна.

ДҮГНЭЛТ

Ажлын хэсгээс удирдамжид заасны дагуу гомдол гаргагчийн хөндсөн асуудлуудыг судлан байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төвлөрүүлэлт, түрээсийн гэрээний биелэлт, урсгал засварын ажлын худалдан авалт, гүйцэтгэл, нэг удаагийн тэтгэмж олгосон зардлын зарцуулалт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Монголын балетын хөгжил сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Энхсүвдын 2024 оны 11-р сарын 28-ны өдрийн 11/15 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэн ДБЭТ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуягийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/10 дугаартай “Урын санд уран бүтээл хүлээж авах тухай” тушаалаар “Цөмөөхэй” бүжгэн жүжгийн оюуны өмчийн эрх, партитур, цомнол, тайзны иж бүрдэл, хувцасны иж бүрдэл, тайз, хувцасны эскиз зэрэг иж бүрдлээр нь театрын урын санд бүртгэх шийдвэр гарчээ.

“Цөмөөхэй” жүжгийг 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүртэл нийт 9-н удаа тайзнаа тоглож тасалбарыг тикет.мн-ээр болон театрын кассаар нийт 253,990.0 мянган төгрөгийн орлого олж, нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжийн дагуу бүртгэж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан байна.

2. “Цөмөөхэй” бүжгэн жүжиг нь 2024 оны 12 дугаар сард 9 удаа тоглоход 6 өдөр нь үзэгчдэд цай, кофегоор үйлчлэх зориулалтаар 2 түрээсийн гэрээ байгуулсан байна. Гэрээний гүйцэтгэлийг хянахад гэрээг дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийг хэрхэн хангасан тухай тайлан байхгүй, бартерын орлогыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг ерөнхий нягтлан бодогч буюу санхүүгийн албаны дарга, нярав, үйлчилгээний албаны дарга нар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3. Тус байгууллагад тайз түрээсийн төлбөрийг зохицуулсан журам батлагдаагүй, Захирлын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Тайз түрээсийн үнэ, жилийн суудлын үнийн тарифийг шинэчлэн батлах тухай” А/27 дугаар тушаалыг мөрдөж тайз түрээсийн гэрээг байгуулж иржээ. Тайз түрээсийн 2024 онд нийт 21 гэрээг хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан ба үүнээс 3 байгууллагатай тайзыг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэ төлбөргүй ашиглуулахаар гэрээлсэн байна.

4. Дулааны шугам сүлжээ, өрөөний засвар, ариун цэврийн өрөөний засварын ажлыг гүйцэтгэхээр өмнөх удирдлага Б.Сарантуяа 3 аж ахуйн нэгжтэй 48,677.5 мянган төгрөгийн, одоогийн удирдлага Д.Алтанхуяг 3 аж ахуй нэгж, 3 иргэнтэй 109,999.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.3 дэх

хэсэгт заасан “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” зарчмын 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан заалт, 24 дүгээр зүйлийн 24.4-т заасан заалтай нийцэхгүй байна.

5. Бараа материал бэлтгэн нийлүүлсэн 2 иргэн, 1 аж ахуй нэгжээс худалдан авсан 54,452.5 мянган төгрөгийн эд материалыг 2024 оны санхүүгийн тайланд бараа материалын орлогоор бүртгээгүй, шууд зардалд бүртгэж зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, 13.7, 20.2, 20.2.6-д заасан заалт, мөн Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5. Дуурь бүжгийн эрдмийн театрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 3.1.2, 3.5, 5.1, 5.5 д заасан заалтыг баримтлан ажилтны ажлын үр дүнг харгалзан урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгын хүрээнд Сангийн яамны төрийн санд хандан цалингийн зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 613.3 сая төгрөгийн зарцуулалтын эрх нээлгүүлэн, хууль журмын дагуу 611.3 сая төгрөгийг давхардсан тоогоор 374 ажилтан, 165 ахмад ажилтанд зарцуулан, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор олгож буй орон сууцны урьдчилгаа төлбөрийн тэтгэмж авахад тавих шаардлага, мөнгөн дүнг зохицуулсан заалтыг тусгаж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрт тэтгэмж олгох талаар арга хэмжээ болгон баталж, хэрэгжүүлж ажиллах;
2. Авлигатай тэмцэх газрын 2024 оны 10 дугаар сарын 29-ний 03/17361 дугаар албан бичгээр ирүүлсэн “Зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хангаж “Тайз түрээсийн үнэ, жилийн суудлын үнэ бусад тариф” -ийг батлуулах ажлыг дахин зохион байгуулж, үр дүнг тайлагнах;
3. Ажилдаа хариуцлагагүй хандаж хууль, журам, Албан тушаалын тодорхойлолтыг мөрдөж ажиллаагүй Ерөнхий нягтлан бодогч буюу Санхүүгийн албаны дарга Н.Анхтөр, Нярав О.Энхцэцэг, Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга Х.Одгэрэл болон бусад холбогдох ажилтан, албан хаагчдад зохих арга хэмжээг авч ажиллахыг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуягт даалгах;

ДБЭТ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуягт		Хугацаа
Зөвлөмж 1.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлж ажиллах;	2025 оны 06-р сарын 25-ны дотор
Зөвлөмж 2.	Шилэн дансны тухай хуулийн дагуу захирлын баталсан тушаалыг бүрэн мэдээлэх, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг тухай бүр буюу гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор мэдээлж байх;	
Зөвлөмж 3.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг хатуу мөрдөн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй, санхүүгийн тайланд тусгахгүй байхад анхаарч ажиллах;	
Зөвлөмж 4	Түрээсийн бартерийн орлогыг холбогдох хууль, журамд нийцүүлэн бүртгэж, санхүүгийн тайланд тухай бүр бүрэн тусгаж, тайлагнах;	2025 оны 06-р сарын 25-ны дотор

Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн хариуг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор яамны ХШҮДАГ-т ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo---